



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН
/ЖИЛИЙН ЭЦЭС/

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН
/ЖИЛИЙН ЭЦЭС/

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт-2: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тогтвортой газар ашиглалтад чиглэсэн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг Боловсруулж, хэрэгжүүлэх							
1.2.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Өвөрхангай, Ховд, Говьсүмбэр, Дорноговь, Хөвсгөл	19 аймгийн ГЗБЕТ /Увс, Завхан, Говьсүмбэр, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ, Говь-Алтай/	Эхний хагас жилд: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах үе шатуудад хяналт тавьж, дүгнэлт гарган гүйцэтгэгчид болон ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна. Жилийн эцэст: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн зөв зуралгасан эсэхэд хяналт тавьсан байна. ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, аймгийн ИТХ-аар	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж батлуулсан. 2025 онд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийлгүүлэхээр тендер зарлаж шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Хээрийн судалгааны тодруулалтын ажлыг 2 шаттай хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэгч компанитай сумдад газар дээр нь очиж хяналт тавин хамтран ажилласан. ГЗБЕТөлөвлөгөөг 2026 онд эцэслэн хүлээж авна.	100

586

				тодотгол хийгдсэн	хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна		
1.2.2	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Өмнөговь, Увс, Дундговь, Өвөрхангай, Дундговь, Дорноговь, Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Төв аймгийн 68 сум	Архангай, Булган, Баянхонгор, Говь-Алтай, Сэлэнгэ, Дорноговь, Дундговь, Төв, Өвөрхангай, Завхан, Увс, Ховд, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Хөвсгөл аймгийн 181 сум	<p>Эхний хагас жилд:</p> <p>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах үе шатуудад хяналт тавьж, үе шатны тайлангуудад дүгнэлт гарган гүйцэтгэгчид болон ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна.</p> <p>Жилийн эцэст:</p> <p>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн зөв зураглалсан эсэхэд хяналт тавьсан байна.</p> <p>ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засаар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, сумын ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	16 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын дээдгаврыг шинэчлэн боловсруулж батлуулсан. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй хамт тендер зарлаж шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Хээрийн судалгааны тодруулалтын ажлыг 2 шаттай хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэгч компанитай сумдад газар дээр нь очиж хамтран ажилласан. Мөн Арвайхээр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний үе шатны тайланд дүгнэлт гарган ГЗБГЗЗЕГ газарт хүргүүлсэн.	100
1.2.3	Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг аймгийн Ерөнхий	Үйл ажиллагаа	Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Орхон, Сүхбаатар,	Улсын хэмжээнд 167 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан	<p>Эхний хагас жилд:</p> <p>Хотын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулах талаарх саналаа төсвийн тооцролол</p>	2025 онд Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй Баруунбаян-Улаан, Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Есөнзүйл, Өлзийт сумдын ерөнхий төлөвлөгөөний зургийн төсвийг дээрх сумдын ИТХ-аар батлуулж Хот тосгоны хөгжлийн ерөнхий	100

	архитектортой хамтран зохион байгуулах		Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 132 сум		болон танилцуулгын хамт сумын ИТХ, Засаг даргад хүргүүлсэн байна	төлөвлөгөөний зургийн даалгаврыг боловсруулж хянан батлуулж тус сумдын ЗДТГ-т хүргүүлэн нээлттэй тендэрийг зарлуулсан. Дээрх сумдаас Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Ерөнзүйл сумдын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийг хүлээж авна. Үлдсэн 3 сумын ХТХЕТ-г 2026 онд хийлгэж хүлээж авахаар төлөвлөн ажиллаж байна. Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 300 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг "Эх дэлхий" ХХК боловсруулаж байна.	
1.2.4	Аймгийн төвтэй ойр сумдын судалгааг гаргаж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хилийн цэсийг тэлэх саналыг аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлж ГЗБГЗЗЕТ-т ирүүлэх.	Үйл ажиллагаа	21 аймаг	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан	Эхний хагас жилд: Баруун бүс, Хангайн бүсийн аймгууд аймгийн төвтэй ойр сумдын судалгааг гаргаж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох шаардлагатай эсэх тандан судалгааг хийж, хилийн цэсийг тэлэх саналыг аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлж ГЗБГЗЗЕТ-т ирүүлсэн байна.	Хилийн цэсийг тодотгох, тэлэх шаардлага гараагүй.	100
1.2.5	Төрийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д орон нутгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын объектыг угсрах	-	Системд угсрагдаж баталгаажсан объектын тоо-330	Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системд 2024 онд газрын харилцааны салбарын төлөвлөгөөт	Орон нутгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектыг төрийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим (Шилэн хяналт)-д угсарч Салбарын Улсын	Төрийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д орон нутгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 10 төлөвлөгөөт хяналт шалгалтын объектыг угсарсан.	100

				хяналт шалгалтад хамрагдах 371 объектыг угсарч, Ерөнхий газрын даргаар батлуулсан.	ерөнхий байцаагчаар батлуулсан байна.		
ХОЁР.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
2.1	Киоски төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх	Орон нутгийн төсөв	Нийслэл, дүүрэгт шилээр нэвтрүүлсэн төхөөрөмжийн тоо	Улсын хэмжээнд 2022 оноос эхлэн нийт 21 төхөөрөмжийг нэвтрүүлсэн.	Эхний хагас жилд: Киоски төхөөрөмжийг хүртээмж нэмэгдэж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна.	Энэ онд Арвайхээр, Хархорин, Уянга сумдад 3 киоск төхөөрөмж авсан. Төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна.	100
2.2	Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлын төсөв батлагдсан сумын тоо	2023, 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3 сумын нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодруулалтыг хийсэн.	Эхний хагас жилд: Төсөвт батлагдсан сумын газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлын даалгаврыг хамтран боловсруулж батлуулан ажлыг эхлүүлнэ.	Хархорин сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаврыг 2025.05.19-ний өдөр АД/2025-48 дугаартай ГЗБГЗЗЕГ-ын даргаар батлуулан сумын газрын дуудлага худалдааны орлогоос 19 сая төгрөгөөр "Геомэл" ХХК-тай 2025 оны 07-р сарын 21-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж 4-р улирлын байдлаар сумын ИТХ-аар хэлэлцүүлэн дээрх ажлыг хүлээн аваад байна. Мөн Нарийнтээл сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаврыг 2025.05.27-ний өдөр АД/2025-51 дугаартай ГЗБГЗЗЕГ-ын даргаар батлуулан сумын орон нутгийн хөгжлийн сангийн 19 сая төгрөгийг хийлгэхээр төсөвлөж	100

						6 сард гэрээ байгуулах жагсаалтад орсон байсан нь хагас жилийн төсвийн хэмнэлтийн тодотголоор одоо хүртэл тодорхойгүй төрийн сан дээр мөнгө нь байгаа болно.	
2.5	Атар газраас тариалангийн ангилалд шилжүүлэх саналыг судлаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санал, дүгнэлт боловсруулах.	Үйл ажиллагаа	Ирүүлсэн саналын тоо	"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг гаргаж, тус газрын 2024 оны 1/2901 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.	Эхний хагас жилд: Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна.	Аймгийн нийт бэлчээр нутгийг 2025 онд 299 мониторингийн цэгээр төлөөлүүлэн фото мониторингийн аргаар үнэлсэн. Дээрх ажлын үр дүнг нэгтгэн ГЗБГЗЗЕГ-ын ССГМХ-т цахимаар хүргүүлээд байна.	100

ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 4.1. Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.							
4.1.1	Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухай бүр	-	Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.		
4.1.1	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухай бүр	-	Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад	Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1 дахь заалтыг үндэслэн төрийн	100

100

					<p>нэмэлт өөрчлөлт оруулах боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, тогтоомжийн хэрэгжилтийг ажлыг байгуулсан байна.</p> <p>өөрчлөлт санал хууль хангах зохион байгуулсан байна.</p>	<p>захиргааны албан тушаалд тасралтгүй 5 ба түүнээс дээш жил ажилласан 1 албан хаагчид 6,536,500 төгрөгийн тэтгэмж, урамшуулал олголоо. 3 хүртэлх насны хүүхэдтэй 3 албан хаагчид хүүхэд асрах чөлөө, 2 албан хаагчид жирэмсэн амаржсаны амралт олгов.</p> <p>Шинээр томилогдон Газрын мэдээллийн сангийн сургалтанд хамрагдан сертификат авсан 2 албан хаагчид ГХБХБГ-ын даргын тушаалаар Газрын кадастрын нэгдсэн ситем, Газрын биржийн цахим системд хандах эрх олголоо.</p> <p>Жирэмсэн амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй 4 албан хаагчийн албан үүргийг төрийн албаны нөөцөд бүртгэлтэй 2 иргэнээр түр орон гүйцэтгүүлж албан тушаалын цалинг, 2 мэргэжилтэнд түр хаасран гүйцэтгүүлж цалингийн 40 хувийг тооцон олгож байна.</p>	
4.1.2	<p>Сул болон түр зэгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>Үйл ажиллагаа</p>	<p>Сул болон зэгүй орон тоо</p>	-	<p>Сул болон түр зэгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>ХНУМС-д 40 албан тушаалын тодорхойлолтыг 2025.03.01-ний өдөр оруулж ТА3-өөр хянан батлуулсан. Энэ онд Бүрд, Богд, Өлзийт, Баян-Өндөр 4 сумын Газрын даамлын сул орон тоо гарсан Богд, Бүрд сумын Газрын даамлын сул орон тоог Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд шилжүүлэн томилж нөхөв. Жирэмсэн амаржсаны амралт авсан 2 мэргэжилтний орон тоог төрийн албаны нөөцөд</p>	100

					Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна.	Бүртгэлтэй 2 иргэнээр түр орон гүйцэтгүүлж, хүүхэд эсрах чөлөөтэй 2 албан хаагчийн орон тоог 2 мэргэжилтэнд түр хавсран гүйцэтгүүлж байна. Өлзийт, Баян-Өндөр сумдын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зарлан бүртгэлийн хугацаа эхэлсэн мэдээллийг олон нийтэд түгээж ажиллаж байна. ХАСУМ хянуулах албан тушаалын сул орон тоо гараагүй. Барилгын техникийн хяналт гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай цахилгааны инженер, барилгын инженерүүд, жолоочийг захиалагчийн хяналтын зардлаас цалинжуулан Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж байна.	
4.1.3	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Төлөвлөсөн арга хэмжээний тоо	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" /2021-2025/-ыг баталсан.	"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг хэлэлцүүлэн батлаж хэрэгжүүлж ажиллаж байна. Засгийн Газрын 2024 оны 238 дугаар тогтоолын дагуу 42 албан хаагчийн цалин шинэчлэн тогтоож ХНУМС-д орууллаа. Албан хаагчдын өдрийн хоолны хөнгөлөлтийг 12,000 төгрөгөөр тогтоож эхний 9 сарын байдлаар 42 албан хаагчид 105,220,000 төгрөг олгосон байна. 10 дугаар сарын 01-ний өдрөөс цалингийн сан хүрэлцэхгүй 3500 төгрөг болгон бууруулж олгож 9,261,000 төгрөг зарцууллаа. Байгууллагын 6 ахмад настанд цагаан сар, ахмадын баярыг	100

131

						<p>тохиолдуулан 600,000 төгрөг, ээж эмээ нь нас барсан 2 албан хаагчийн ар гэрт нь 600,000 төгрөг, магистрийн зэрэг хамгаалсан нэг албан хаагчид 100,000 төгрөг, давхардсан тоогоор 70 албан хаагчид нэгдүгээр улирал, хагас жилийн байдлаар улиралын урамшуулалд 39,636,250 төгрөгийг олголоо. Албан хаагчдын томилолтонд 95,680,000 төгрөгийг зарцуулсан. Мөн байгууллагын 2 машиныг засварлахад 4,415,000 төгрөг, компьютер тоног төхөөрөмжийг сайжруулахад 20,296,000 төгрөг зарцуулсан байна. 2025 оны 05 дугаар сард 26, 11 сард 18 албан хаагчийг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт "Гранд мед" эмнэлэгт 1,190,000 төгрөгийн багц бүтэн биеийн үзлэг шинжилгээнд хамруулж байгууллагаас 50 хувь албан хаагчдаас 50 хувийг зарцуулан хамрууллаа. Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор байгаа нөөц боломжоо ашиглан сургалтын өрөөг 5 албан хаагч суух боломжоор ханган тохижууллаа. Цаашид албан ажлын өрөө, байрны хэрэгцээ шаардлагатай байгаа тул Барилгын материалын лабораторийн барилга бариулах саналыг 2025 оны улсын төсвийн төсөлд санал хүргүүлэн зураг төсвийг хийлгэж байна. Нэг өрөөнд 8-9 мэргэжилтэн хувиарлагдаж ажлын байрны</p>
--	--	--	--	--	--	---

					<p>эрүүл ахуй алдагдаж ажил үүргээ гүйцэтгэхэд хүндрэлтэй байна.</p> <p>Албан хаагчдад өөлийн улиралд ханиад томуу, эрүүл мэндэд эрсдэл үүсэхээс сэргийлж биеийн дархлаа дэмжих зорилгоор 205,000 төгрөгийн шар тос, аарц худалдан авч буцалган өгч байна.</p> <p>Байгууллагын ариун цэвэр, албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж гар угаах хэрэгсэл, алчуур, цаас авахад зориулж 293,000 төгрөг зарцуулсан байна.</p> <p>Байгууллагын гадна дотор орчныг камержуулах ажлыг 3,540,000 төгрөгөөр гүйцэтгүүлээ. Барилга, газрын 2 байцаагчийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хамгаалах хувцас хэрэглэлийг 1,710,000 төгрөгөөр худалдан авч өглөө.</p> <p>Барилгын техникийн хяналтаар ажилладаг албан хаагчид болон үйлчилгээ явуулж буй ААН-үүдийн инженер, техникийн ажилчдад ХАБЗА-н сургалтын 2,000,000 төгрөгөөр авч 45 хүн хамрууллаа.</p> <p>Хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилийн байдлаар гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлээ.</p>	
4.1.4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагаа	Мэдээллийн тоо		<p>Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй</p> <p>12 удаагийн давтамжаар нийт 182 мэдээллийн хугацаандаа байршууллаа. Үүнд Төсөв, гүйцэтгэлийн талаар 71 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 38 мэдээлэл, бусад санхүүгийн 73 мэдээллийг тус тус оруулсан байна.</p>	100

					адилгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, алага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж баталгаажуулсан байна	ГЗБЗЗЕГ-аараас өгсөн чиглэлийн дагуу батлагдсан орон тооны мэдээллийг дэлгэрүүлсэн. Мөн Засаг даргын захирамж болон түүнтэй адилгах дээд газрын шийдвэрүүдийг хавсралт файлд цэсэнд байршуулж ажиллалаа.	
4.1.5	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах	Үйл ажиллагаа	Тайлангийн тоо	2022 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Байгууллагын хамтээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна. Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБЗЗЕГ-т хягас, бүтэн жилээр хүргүүлсэн байна.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлж байна. Сумдын Газрын даамлуудын 1 дүгээр улиралын сургалтаар ёс зүйн дэд хорооноос авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ёс зүйтэй байх талаар сургалт мэдээлэл хүргэсэн. Газрын даамлуудаас үйлчилгээ авч байгаа иргэдээс сэтгэл ханамж, ажилтны харилцаа хандлагын талаар судалгаа авч байна.	100
4.1.6	Албан тушаалтнуудын 2024 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Мэдүүлэг гаргагчийн тоо	2021 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн.	Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө авах ажлыг зохион байгуулсан байна.	5 албан хаагчийн 2024 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг авах ажлыг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө хугацаанд нь зохион байгууллаа. Хугацаандаа бүгд үнэн зөв мэдүүлсэн тухай 5 төрлийн мэдээ тайланг Аймгийн ЗДТГ Хууль эрхзүйн хэлтэст 2025.02.15-нд хүргүүлсэн.	100

4.1.7	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх	Үйл ажиллагаа	Мэдүүлгийн тоо	-	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	Төгрөг санг сумын сургуулийн дотуур байрны дэвэрийн засварын ажлыг хүлээн авах улсын комисст ажилласан дөвхөрдсөн тоогоор 6 албан хаагчийн Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэж, шийдвэрлэсэн.	100
4.1.8	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Мэдүүлгийн тоо	-	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Аалигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.	Шинээр нийтийн албан томилогдохоор нэр дэвшсэн албан хаагч байхгүй.	-

Төлөөлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

(огноо)

Төлөөлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР-ЫН ДАРГА

Т.АРИУНБОЛД

(огноо)

2023.12.03

Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын
18-ны өдрийн 3-2/642 дугаар албан бичгийн
нэгдүгээр хавсралт хавсралт

ОРОН НУТАГТ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

д/д	Зорилт	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Төсөв	Хүрсэн түвшин (шалгуур үзүүлэлтийн дагуу тоо баримтаар тайлагнана) Хэрэгжилтийн хувийг бичнэ (0,30,70,100)	Хариуцан хэрэгжүүлэх хэлтэс, байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага
Нэг. Хүний эрхийг хангах үндэсний механизмийг дэмжих чиглэлээр								
1.	1.1. Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний механизмийг дэмжиж ажиллана	1.1.1. Хүний эрхийн Үндэсний Комиссын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж ажиллах.	1-4 улирал	Хэрэгжүүлсэн шаардлага зөвлөмж	-	Хүний эрхийн үндэсний комиссоос хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын хариуцлага, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг гарган 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хугацаанд нь ЗДТГ-т хүргүүлээ.		100
		1.1.2. Олон Улсын Хүний эрхийн өдрийн хүрээнд тодорхой ажил зохион байгуулах.	4-р улирал	Зохион байгуулсан үйл ажиллагаа	-			
		1.1.3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг сурталчлах, хэрэгжүүлэх.	1-4-р улирал	Зохион байгуулсан үйл ажиллагаа	-			

186

		1.1.6. Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутаг дахь ажилтны санаачилсан ажил, хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг дэмжих, санхүүжүүлэх.	1-4 улирал	Зохион байгуулсан үйл ажиллагаа, санхүүжүүлсэн үйл ажиллагаа		Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутаг дахь ажилтны хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, сургалтыг албан хаагчдын хүний эрхийн боловсролыг нэмэгдүүлэхээр "Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр нийт албан хаагчдад зохион байгуулж хамтран ажиллав.		100
Хоёр. Хүний суурь эрхийг хангах үйл ажиллагааны чиглэлээр:								
2.	2.1. Хүний хувийн эрх, эрх чөлөөг хангана.	2.1.1. Төрийн байгууллагын мэдээллийн сан түүний хамгаалалт, кибер орчин дахь гэмт хэрэг, мэдээллийн дэд бүтцэд хууль бусаар нөлөөлөх шинж байдлыг шинжлэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	1-4 улирал	Зохион байгуулсан сургалтын тоо	Хөтөлбөрийн санхүүжилтээр	Өвөрхангай аймгийн цагдаагийн газар, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, прокурорын газраас хамтран зохион байгуулсан "Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд байгууллагаас 3 албан хаагч Орхон кино театрт хамрагдлаа. Мөн байгууллагын сургалтын танхимд аймгийн цагдаагийн газрын кибер гэмт хэрэгтэй тэмцэх тасгаас нийт албан хаагчдад сургалт зохион байгууллаа.		100
		2.1.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, иргэд, олон	1-4 улирал	Зохион байгуулсан арга хэмжээний тоо		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган хуулийн дагуу 68 төрлийн нээлттэй мэдээллийг байгууллагын вэб хуудас ovorkhangai.gazar.gov.mn болон shilen.gov.mn сайтад тухай байршуулж шинчлэж хэвшсэн.		100

		нийтийн мэдээлэл авах эрхийг хангах						
		2.1.3.Цахим аюулгүй байдлын чиглэлээр хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангах талаарх мэдээллийг олон нийтэд сурталчилан таниулах	1-4 улирал	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо		Цахим аюулгүй байдлын чиглэлээр, хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангах талаар хуулийн дагуу арга хэмжээ авч хүний хувийн мэдээлэл цуглуулагч албан хаагчидтай нууц хариуцсан ажилтан нууцын баталгаа гарган, гэрээ байгуулан, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хянан дүгнэж ажиллаж байна.		100
Гурав. Тулгамдаж буй хүний эрхийн зөрчил, түүнийг арилгах чиглэлээр:								
3.	Орон нутагт 1-4 хүртэлх жил үргэлжилж буй төрийн албан хаагчийн тодорхой үйлдэл, эс үйлдэхгүйн улмаас үүссэн хүний эрхийн зөрчлийг тодорхойлж, таслан зогсооход чиглэнэ.	3.1.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах.	1-4 дүгээр улирал	Зохион байгуулсан сургалтын тоо		Байгууллагын ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Сумдын Газрын даамлуудыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 17-нд танхимаар зохион байгуулаа. Энэ үеэр бүх албан хаагчдад ёс зүйн дэд хорооноос төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зохицуулалтын талаар сургалт сургалт хийв. Албан хаагчдыг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад хамруулж Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагатай холбоотой 2 чиглэлийн сургалтад оролцуулсан. Төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх, байгууллагын эд хөрөнгө техник хэрэгслийг хувийн зорилгоор ашиглахгүй байх талаар албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна. Байгууллагын болон адбаны нууцыг хадгалах, задруулахгүй байх талаар нууцтай холбогдох албан хаагчид байгууллагын нууцын асуудал хариуцсан ажилтантай гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган биелүүлж байна.		100

					<p>Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор Монгол хүний үнэ цэнэ сэдэвт лекцид албан хаагчдаа хамрууллаа.</p> <p>Ажлын цагийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байранд албан хувицаслах, албан бус үг хэллэг хэрэглэхгүй байх, хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх талаар байгууллагын хурал, зөвлөгөөн байнга сануулдаг.</p> <p>2025 онд ёс зүйн сахилга хариуцлагын талаар өргөдөл гомдол ирээгүй.</p> <p>Хэрэгжилт 100 хувь</p>		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛЭХ МЭРГЭЖИЛТЭН Г.ДУЛАМДОРЖ

ХЯНАСАН

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА АРИУНБОЛД



ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2025 ОНД ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

Д /д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжих хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр (сая.төгрөг)	Тайлбар	Хэрэгжилт
Хот байгуулалтын чиглэлээр							
1	Хот байгуулалтын чиглэлээр тухайн жилд хийгдсэн ажлын талаарх тайланг /2025.12.15-ны өдрийн дотор/	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх	Тайланг ХББОСЯ-нд хүргүүлж, дүгнүүлнэ.	I-IV улиралд	-	Хот байгуулалтын чиглэлээр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын судалгааг 4 дүгээр улиралд бүрэн дуусгаж ХББОСЯ-нд хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Аймгийн ерөнхий архитекторын тайланг хугацаанд нь 2026 оны 01 сарын 18 дотор хүргүүлэхээр төлөвлөж байна.	Хэрэгжсэн
2	Хот байгуулалтын кадастрын цахим системийг аймгийн хэмжээнд хөтлөх, өгөгдөл, мэдээллийг тогтмол шинэчлэх, бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх, хяналт тавих	Холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хийгдсэн байх	Хот байгуулалтын кадастрын цахим системийн тасралтгүй үйл ажиллагааг хангасан байна.	I-IV улиралд	-	2025 онд архитектур төлөвлөлтийн даалгавар 50, барилгын ажил эхлүүлэх 36, сунгалтын 5 зөвшөөрөл, барилга ашиглалтанд оруулах комиссын дүгнэлт 16 хүсэлтийн дагуу шийдвэрлэж шинэчлэгдсэн "Хот байгуулалтын кадастр"-ын цахим системд боловсруулалт хийж гаргаж Хот байгуулалтын кадастрын цахим системийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна.	Хэрэгжсэн
3	Аймгийн төвүүдийн орон сууцны хорооллуудад хот байгуулалт, барилгын хяналтыг хэрэгжүүлж, төлөвлөлтийг норм,	Холбогдох хууль, норм, дүрэм, стандартын дагуу	Аймгийн төвүүдийн орон сууцны хорооллуудад хот төлөвлөлт,	I-IV улиралд	-	Орон сууцны хорооллуудад хот төлөвлөлт, барилгын норм, стандартын шаардлагыг хангуулах ажлын хүрээнд 05 дугаар сард 19 сумын иргэд албан байгууллага, барилгын	Хэрэгжсэн

	стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах	хийгдсэн байх	барилгын норм, стандартын шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулж үр дүнг ХББОСЯ-нд тайлагнасан байна.			салбарын төлөөлөгчдийг оролцуулан "Нийтийн эдэлбэр талбайг ашиглах, хянах журам"-ын төслийн танилцуулга хэлэлцүүлгийг аймгийн "Хүүхдийн ордон" -нд зохион байгуулан ажиллаж аймгийн ИТХ-аар батлуулахаар төслийн саналыг хүргүүлэн ажилласан.	
4	Аймаг сумын төвүүдэд хот байгуулалтын бүсчлэл, улаан шугам болон өндөржилтийн зураглалыг боловсруулж баталгаажуулан, газар ашиглалт, барилгажилтын үйл ажиллагаанд мөрдөх	Холбогдох хууль, норм, дүрэм, стандартын дагуу хийж мөрдсөн байх	Аймаг, сумын төв тус бүрээр хот байгуулалтын бүсчлэл, улаан шугам болон өндөржилтийн зураглалыг боловсруулах мөрдөх ажлыг зохион байгуулж үр дүнг ХББОСЯ-нд тайлагнасан байна.	I-IV улиралд	-	Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хот байгуулалтын бүсчлэл, улаан шугам болон өндөржилтийн зураглалыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний даалгаварт тусган мөрдөх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. 2025 оны ХТХЕТ-гүй Баруунбаян-Улаан, Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Есөнзүйл, Өлзийт сумдын ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаварт Хот байгуулалтын бүсчлэл, улаан шугам болон өндөржилтийн зураглалыг хийлгэхээр боловсруулан ажилласан болно. Энэ онд дээрх сумдаас Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Есөнзүйл сумдын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийг хүлээж авна.	Хэрэгжсэн

5	<p>Хот суурин газрын дахин хөгжүүлэх төслийг санаачлан хэрэгжүүлэх</p> <p>-Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан дахин төлөвлөн барилгажуулах</p> <p>-Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих</p> <p>-Гэр хорооллын дахин зохион байгуулах</p> <p>-Гэр хорооллын дахин зохион төлөвлөн барилгажуулах</p> <p>-Нийтийн эдэлбэр гээрийг дахин төлөвлөн байгуулах</p>	<p>Холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулах</p>	<p>Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн төсөл боловсруулж, хэрэгжүүлсэн байна.</p>	I-IV улиралд	Орон нутгийн төсөв 770.0 сая	<p>2025 онд Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдээгүй Баруунбаян-Улаан, Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Төгрөг, Есөнзүйл, Өлзийт сумдын ерөнхий төлөвлөгөөний зургийн төсвийг дээрх сумдын ИТХ-аар батлуулж Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг боловсруулж хянан батлуулж тус сумдын ЗДТГ-т хүргүүлэн нээлттэй тендэрийг зарлуулсан.</p> <p>Энэ онд дээрх сумдаас Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Есөнзүйл сумдын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийг хүлээж авна. Үлдсэн 3 сумын ХТХЕТ-г 2026 онд хийлгэж хүлээж авахаар төлөвлөн ажиллаж байгаа болно.</p>	Хэрэгжсэн
6	<p>Аймаг, сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх</p>	<p>Холбогдох хууль, норм, дүрмийн шаардлагыг хангасан байх</p>	<p>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, ИТХ-аар батлуулсан байна.</p>	I-IV улиралд	Орон нутгийн төсөв 280.0 сая	<p>Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 300 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг "Эх дэлхий" ХХК боловсруулаж байна. Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Есөнзүйл сумдын хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаварт Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг хийлгэхээр боловсруулан ажилласан. Тус сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд орон сууцны</p>	Хэрэгжсэн

						хороололын жижиг хэсэгчилсэн төлөвлөгөө хууль норм дүрмийн дагуу төлөвлөгдөж байгаа болно.	
7	Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартуудыг аймагт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах /MNS ISO 37100:2024, 37101:2024, 37120:2024, 37122:2024, 37123:2024/	Холбогдох хуулиудын дагуу хэрэгжүүлнэ	Батлагдсан 5 стандартыг нэвтрүүлэх төлөвлөгөө гаргаж, ажлын хэсгийг байгуулж ажилласан байна.	I-IV улиралд	-	Засгийн газар чиглэлийн яамнуудаас чиглэл заавар ирээгүй болно.	
8	Сумын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах	Холбогдох хууль, норм, дүрмийн шаардлагыг хангасан байх	Эхний ээлжинд 2025 онд Хархорин, Есөнзүйл, Баян-Өндөр, Нарийнтээл сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусган батлуулсан байна.	I-IV улиралд	Орон нутгийн төсөв 340.0 сая	Энэ онд ХТХЕТ-ний зураг хийлгэхээр Баруунбаян-Улаан сум 150 сая, Баян-Өндөр сум 150 сая, Бүрд сум 200 сая, Зүүнбаян-Улаан сум 150 сая, Есөнзүйл сум 150 сая, Тарагт сум 150 сая, Өлзийт сум 150 сая төгрөгийн төсвийг дээрх сумдын ИТХ-аар батлуулж Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг боловсруулан хянан батлуулж тус сумдын ЗДТГ-т хүргүүлэн нээлттэй тендэрийг зарлуулсан. Бүрд, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Есөнзүйл сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн гүйцэтгэгчээр "Эрхэт контрактш" ХХК шалгарсан ондоо багтаан хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.	Хэрэгжсэн
БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР							
1	Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх,	Барилгын тоо	Орон нутгийн төсөвт	II, IV улиралд	-	Арвайхээр сумын 1, 2 дугаар сургууль, 2 дугаар цэцэрлэгийн	Хэрэгжээгүй

	барилга байгууламжийг паспортжуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж шинээр барих, үерийн даланг хүчитгэх		гамшгаас хамгаалах чиглэлээр санхүүжилт тусгаж барилга байгууламжийг паспортжуулж газар хөдлөлтөд тэсвэртэй болгох арга хэмжээ авсан байна. Тухайн жилийнхээ төсвийн 1-ээс дээш хувийг зарцуулсан байна.			барилга, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн (А блок яаралтай тусламжийн тасаг, эрчимт эмчилгээний тасаг, дэмжих үйлчилгээний төв, Б блок дотор арьсны клиник, дүрс оношилгооны тасаг, ангиографийн хэсэг, мэс заслын тасаг, В блок сэтгэц наркалогийн тасаг, дотор арьсны клиникийн амбулатори, эмч нарын өрөө, нэгдсэн амбулатори, багаж ариутгалын хэсэг, уламжлалтын амбулатори, эмчилгээний өрөө, Г блок захиргааны хэсэг, мэдрэлийн тасаг, мэдрэлийн амбулатори, өдрийн эмчилгээний өрөөнүүд) 1997 онд баригдсан тоосгон өрөгт бүтээц бүхий хуучин 4 барилгад Улаанбаатар хотын "Бүүвэй цагаан барс" ХХКомпаниар паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргуулж, Нийт 7 барилгад дүгнэлт гаргуулаад байна. 2026 онд олон нийтийн орон сууцны хуучин 3 барилгыг паспортжуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
2	"Ногоон" барилгын үзэл баримтлалыг хэрэгжүүлэн ажиллах	Журмын хэрэгжилтийн хувь	"Bestger" ногоон барилгын үнэлгээний аргачлал, "Ногоон" барилгыг гэрчилгээжүүл	I-IV улиралд	-	Өвөрхангай аймагт "Ногоон" барилгын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын амины орон сууцны иновац хөгжлийн төв, аймгийн ЗДТГ, "Төрийн банк" "Ногоон" барилгын мэргэжлийн хувийн байгууллагуудтай хамтран	Хэрэгжсэн

h/h

			эх журам"-ыг хэрэгжилт хангагдсан байна. Барилга байгууламжийн төсөл хөтөлбөрт ногоон барилгын шаардлагыг хангуулсан байна.			"Тогтвортой хөгжил, Ногоон ирээдүй" үзэсгэлэн худалдааг ХДТ-ын 1 дүгээр давхарт, "Орон нутагт эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх боломж" сэдэвт хэлэлцүүлгийг ХДТ тоглолтын их танхимд иргэдэд болон барилгын салбарын ААН-байгууллагуудад мэдээлэл өгч асуулт хариулт хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан.	
3	Барилгын салбарт мэдээлэлтэй загварчлал /BIM/ нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллах хүрээнд томоохон төсөл хөтөлбөрийг BIM-ээр хэрэгжүүлэх	Төсөл-1	BIM-ээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байх	I-IV улиралд	-	Барилгын салбарт мэдээлэлтэй загварчлал /BIM/ нэвтрүүлэхээр программ худалдан авахаар төчөвлөж Шинжлэх ухаан технологийн их сургуулийн техникийн ухааны магистр, доктрант, барилгын зөвлөх үйлчилгээний "Эрдэм түм" ХХК-ийн захирал Л.Түмэндэмбэрэл багштай хамтран BIM системээр төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянах ажлын даалгаврыг боловсруулж программ хөгжүүлэгчид хүргүүлсэн.	Хэрэгжсэн
4	Аймгийн барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлэх	-Тоног төхөөрөмжийн тоо -Байрны хүчин чадал	Лабораторийн байрыг сайжруулж, техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна.	I-IV улиралд	-	Жилийн эцсийн байдлаар Аймгийн барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлэх, ажлын байрыг сайжруулах, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд	Хэрэгжсэн

105

						<p>Бетон шоо сорьцийг турших механик прессийг сольж шинэчлэхээр багаж тоног төхөөрөмжийн үнийн мэдээллийг судлаж хөрөнгө санхүүг шийдүүлэх шатандаа ажиллаж байна. Мөн лабораторт ирүүлсэн сорьц дээжид шинжлэгээ хийхэд хэрэглэдэг жижиг хэрэгслүүдийг солих, хэмжих хэрэгслүүдийг болон тоног төхөөрөмжүүдийг "ЭТАЛОН ХЭМЖҮҮР"-ийн газраар жил бүр хэмжилт баталгаажуулалт хийлгэн хамтран ажиллаж байна. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн чадавхыг дээшлүүлэх ажлаар итгэмжлэлийн хүрээнд бетоны орцын норм тогтоох, хар замаск, хуванцар хийцлэл, цонх, арматур зэрэг барилгын материалуудын физик, механик шинж чанарыг тодорхойлох, үр дүнг баталгаажуулж итгэмжлэлийн хүрээгээ өргөжүүлэхээр ажиллаж байна.</p>	
5	<p>Барилгын салбарт "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн" аяныг төлөвлөх, эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулах</p>	<p>-Арга хэмжээний тоо</p>	<p>"Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн" аян зохион байгуулж тухайн аймагт барилгын үйл ажиллагаанд</p>	<p>II, IV улиралд</p>	-	<p>Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, техник, технологийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Аюулгүй байдал-Аюулгүй ажиллагаа" аяныг 2025 оны 05 дугаар сарын 27-оос 08 дугаар сарын 30-ны</p>	<p>Хэрэгжсэн</p>

			оролцогч нарыг хамруулж мэдлэгээр хангасан байна.			хооронд зохион байгуулах төлөвлөгөөг батлав. Төлөвлөгөөний дагуу улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа нийт 25 барилга угсралтын ажилд урьдчилан сэргийлэх шалгалт хийж ажил сайжруулах зорилгоор хугацаатай үүрэг даалгавар өгөн биелэлтийг хангуулан ажиллаж байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны мэргэшсэн 124 цагийн сургалтыг энэ оны 04 сард Арвайхээр хотод "Эрхэс сувд" ХХК-тай хамтран 40 гаруй байгууллагын 51 инженер, техникийн ажилчидыг хамруулсан. 2025 оны 06 дугаар сарын 13-нд Хархорин суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 28 инженер техникийн ажилчдад "Ололт амжилт" ХХК-тай хамтран ХАБЭА-н сургалтыг зохион байгууллаа.	
Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр							
1	Үйлдвэрлэлийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг даалгаврыг хянах, барилга угсралт, ашиглалтын явцад хяналт тавих, цэвэрлэгдээд гарч буй	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдсан байх	Урьдчилсан цэвэрлэх байгууламжид хяналт тавих ажилтанг ЗДТГ-д ажиллуулсан байна.	I-IV улиралд	-	Цэвэрлэх байгууламжийн барилга угсралт, ашиглалтын явцад хяналт тавих дэд бүтцийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэнг аймгийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж байна. Ажлын даалгаврыг хянах, зураг төсөл боловсруулах, цэвэрлэгдээд гарч	Хэрэгжсэн

14

	усанд хяналт тавих, нэгдсэн удирдлага, хяналтын тогтолцоо бий болгох чиг үүрэг бүхий ажилтанг аймгийн Засаг даргын бүтцэд бий болгон ажиллах					буй усанд хяналт тавих ажлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд хариуцан ажиллаж байна.	
2	Сууц өмчлөгчдийн холбоодын бүртгэл, мэдээллийг Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн системд оруулж, тухай бүр баяжилт, хөтлөлтийг хийх	Сууц өмчлөгчдийн холбоодын цахим бүртгэл, мэдээлэлтэй болох	Сууц өмчлөгчдийн холбоодын цахим бүртгэл, мэдээлэлтэй болсон байна.	IV улиралд	-	Төрийн үйлчилгээг үе шаттай цахимжуулах ажлын хүрээнд Өвөрхангай аймагт бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй сууц өмчлөгчдийн холбоодын дэлгэрэнгүй мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 3/233 дугаартай албан бичгээр болон цахим хаягаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлэн судалгааг нэгтгэн авч Сууц өмчлөгчдийн холбооны нэгдсэн бүртгэл болох mcis.gov.mn цахим мэдээллийн санд баяжилт хийж ажиллав.	Хэрэгжсэн
3	Шар усны үерийн болон ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийх	Шар усны үерийн болон ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөтэй болох	Эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байна.	IV улиралд	-	Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдэлийн үнэлгээг хийхээр холбогдох байгууллагуудтай зөвшилцөж төлөвлөн ажиллаж байна.	
4	Орон нутгийн өмчит аж ахуйн байгууллагын зардал нөхөх	Зардал нөхөх төлөвлөгөө	Зардал нөхөх төлөвлөгөө	IV улиралд	-	Орон нутгийн өмчит аж ахуйн байгууллагын зардал нөхөх төлөвлөгөөг 2024-2030 он хүртэл	Хэрэгжсэн

	<p>төлөвлөгөөг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороотой хамтран боловсруулж, батлуулах хэрэгжүүлэх</p>	<p>боловсруулах</p>	<p>хэрэгжүүлсэн байна.</p>			<p>2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороогоор 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
5	<p>Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх хийх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, мэдээллийн сангуудыг нэгтгэж, хамгаалалтын зурваст газар олгогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, ажлыг зохион байгуулах</p>	<p>Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт төлөвлөлт, ажлын даалгавар, ажлын гүйцэтгэлийн дагуу</p>	<p>Аймгийн хэмжээнд "Байр зүйн дэвсгэр тоон зураг, дэд бүтцийн мэдээллийн сан" болон "Хот байгуулалтын мэдээллийн сан"-д хот, суурин газруудын газар дээрх болон газар доорх инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний мэдээллээр тогтмол баяжилт хийх ажлыг зохион байгуулж бүтэн жилээр тайлагнаж байна.</p>	<p>IV улиралд</p>		<p>Инженерийн шугам сүлжээний хамгаалалт, хориглолтын бүсийн холбогдох бичиг баримт мэдээллийг боловсруулан захирамжаар хамгаалалтын бүсийг тогтоохоор ажиллаж байна. Захирамж гарсанаар инженерийн шугам сүлжээний хамгаалалт, хориглолтын бүсийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэн оруулах ажлыг зохион байгуулна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор цэвэр ус хангамжийн хориглолт хамгаалалтын бүсчлэлийг тогтоосон. Энэ тогтоолын дагуу инженерийн шугам сүлжээний хамгаалалт, хориглолтын бүсийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэн оруулах ажлыг зохион байгуулан тогтоолын хэвсрэлтэд дурдсан шугам сүлжээний трассыг зурган файл хэлбэрт хөрвүүлэх ажил хийгддэг байна. Хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар Хот байгуулалт, барилга, орон</p>	<p>Хэрэгжсэн</p>

						сууцжуулалтын яаманд хүргүүлнэ.	
6	ШУТИС-БАСургуулийг түшиглэн Нийтийн аж ахуйн салбарын ажилтаныг чадавхжуулах, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тэтгэлэгт хөтөлбөртэйгөөр байгуулж байгаа ангид аймаг, суманд ажилтах 1 хүнийг сургаж бэлтгэх талаар хамтран ажиллах	Суралцагчийн тоо-1	Аймаг, суманд ажиллах нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцөөр хангагдах боломж бүрдэнэ.	I-IV улиралд	-	Хугацаа болоогүй.	
Орон сууцны чиглэлээр							
1	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1.6-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор ипотекийн зээлийн санхүүжилтийг амины орон сууцад олгох тогтолцоог бүрдүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Аймаг, сумын төв, суурин газруудын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг улсын орон зайн нэгдсэн цахим мэдээллийн	Цахим системд хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоо	Аймаг, сумын төв, суурин газруудад амины орон сууцны бүсийг тодорхойлж цахим системд оруулсан байна.	I-IV улиралд	-	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэгдээгүй Сант, Төгрөг, Бат-Өлзий сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг цахим системд бүрэн оруулсан. 2025 онд шинээр хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа Бүрд, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 300 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зургийг дуусган улсын орон зайн нэгдсэн цахим	Хэрэгжсэн

	сангийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд иж бүрнээр оруулах, иргэд олон нийт болон зээл олгогч арилжааны банкуудад нээлттэй мэдээлэх, сурталчлах					мэдээллийн сангийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулж буй эсэхэд хяналт тавьж хүлээн авах шатанд байна.	
2	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1.4-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан орон нутгийн 91 хөгжлийн төвд төрийн албан хаагчдын түрээсийн 8 айлын орон сууц барих ажлын хүрээнд хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд туссан газрыг нөөцөд авч, инженерийн дэд бүтцийн шийдлийг боловсруулж, төсөл хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангасан талаарх мэдээллийг тус яаманд шуурхай ирүүлэх	-Орон сууцны зориулалттай газар - Инженерийн дэд бүтцийн шийдэл бүхий мэдээлэл	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан орон нутгийн 91 хөгжлийн төвд орон сууцны зориулалттай газар, дэд бүтцийн бэлэн байдлын мэдээллийн хамт бий болсон байна.	I-IV улиралд	5,000.0	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцаас Сант, Бүрд, Хужирт, Бат-Өлзий, Богд сумдад төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц барихаар гүйцэтгэгчийг шалгаруулсан. Төрийн албан хаагчдын орон сууцны техникийн нөхцлүүдийг гаргаж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн. Орон сууц барих газрын асуудлыг шийдвэрлэсэн. Төндөрт шалгарсан Бага хайлантай ХХК Хужирт суманд төрийн албан хаагчийн 8 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлээд 60 хувийн гүйцэтгэлтэй байна.	Хэрэгжсэн

3	Амины орон сууцны технологи дамжуулах төвийг шинээр байгуулж, ногоон, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барихад иргэдийг мэдээллээр хангах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх	Технологи дамжуулах төв-1	Иргэд мэдээ мэдээллээр бүрэн хангагдаж, ногоон, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцтай болох боломж бүрдсэн байна.	I-IV улиралд	Ногоон барилгын "Bestger" үнэлгээний аргачлал, гэрчилгээжүүлэх журмын танилцуулах сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний танилцуулга, худалдаа, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны инновац хөгжлийн төвийн дүгнэлттэй зураг, төслийн танилцуулга гэх мэт мэдээллийг иргэд, олон нийтийг хамрууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн банк, Амины орон сууцны инновац хөгжлийн төв, Huawei Mongolia, Monhorus Erchim, Clean Resource Development CRD хамтран энэ оны 05 дугар сарын 26-ны өдөр "Орон нутагт эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх боломж" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж иргэдэд мэдээлэл хүргэлээ. Ногоон, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц барих нөхцөл бүрдэж байна.	Хэрэгжсэн
---	---	---------------------------	--	--------------	--	-----------

152

БАТАЛГААНЫ ХУУДАС

Энэ хадгаламжийн нэгжид 152 (15а Зүүн талын нэгж)
хуудас + дотоод товчбөгийн

(тоо, үсгээр)

1 (15а) хуудас бүгд 153 (15а Зүүн талын сурал)
(тоо, үсгээр) (тоо, үсгээр)
хуудас дугаарлав.

Алгассан хуудасны дугаар _____

Давхардсан хуудасны дугаар _____

Гэрэл зургийн хуудасны дугаар _____


А3, А2 хэмжээтэй хуудасны дугаар _____

Дутуй болон дутгуйд буй баримтын хуудасны дугаар _____

Гэмтэлтэй, сэргээн засварласан хуудасны дугаар _____

БАТАЛГААНЫ ХУУДАС БИЧСЭН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
албан тушаал


гарын үсэг

Г.ДУЛАМДОРЖ
гарын үсгийн тайлал

2026 оны 01 дүгээр сарын 08